

Энэхүү нийтлэлийг дараах хаягаар үнэ төлбөргүй авч болно.

**Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь Хөтөлбөрийн газар
(WWF Mongolia Programme Office)**

Худалдааны гудам- 5, Улаанбаатар-46
Монгол Улс

Утас:+976-11-311-659
Факс:+976 11 310 237
E-mail: wwfmon@magicnet.mn
Вэб: <http://www.wwf.mn>

Нэмэлт мэдээлэл:

<http://www.europa.eu.int/comm/environment/water/>
E-mail: env-water@cec.eu.int

Орчуулсан:

Д.Оюунбаатар, Н.Батнасан

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь Хөтөлбөрийн газар,
2005 он

Европын Комиссын Байгаль орчны Захирлын Ажлын Алба

Европын Холбооны талаарх нэмэлт мэдээллийг интернетээс үзэж болно.
<http://europa.eu.int>

Каталогийн дугаарыг арын хуудаснаас үзэж болно.

Люксембург: Европын Холбооны Албан ёсны Хэвлэлийн Газар, 2005 он

ISBN 92-894-8307-5

© Европын Холбоо, 2005
Хэвлэлийн эх үүсвэрийг дурдан дахин олшруулан ашиглаж болно.

Бельги улсад хэвлэв.

Дахин боловсруулсан цаас ашиглав.



ISBN 92-894-8307-5



9 789289 483070

КН-11-01-325/АМ-С



Европын Холбооны Усны тухай Ерөнхий Хууль Харилцан суралцъя!



Европын Комисс

Европын Холбооны Усны тухай Ерөнхий Хууль

Ус бол амьдралыг тэтгэгч эх үүсвэр

Манай гаригийн амьд байгалийн амин сүнс нь ус бөгөөд бидний аж амьдрал, аж ахуйн үйл ажиллагаа бүхэлдээ уснаас л хамаардаг билээ. Гэтэл манай гаригийн хэмжээнд нийтэд нь авч үзвэл, ус бол харьцангуй хязгаарлагдмал нөөц баялаг.



Усны нөөцийг ийнхүү хайр гамгүй ашиглан, үлэмж их ачаалал үзүүлж байгаа өнөө үед эдгээр хүндрэлтэй асуудлуудыг зохицуулах үр нөлөөтэй хууль эрхийн механизм бий болгох нь усны нөөцийг хойч үеийнхэндээ хадгалж үлдээхэд маш чухал үүрэгтэй болно.

Иймд Европын Холбооны Усны тухай ерөнхий хууль нь ус хамгаалах ажлын цар хүрээг улам өргөжүүлж, усны бүх объектуудыг бүрэн хамрах болсноор 2015 оны түвшинд Европын бүх усыг "сайн" гэсэн зэрэглэлд хүргэсэн байх тодорхой зорилт тавьж байна. Энэ нь Европ даяар усаа тогтвортой ашиглахын баталгаа болох юм. Усны ашиглалт хамгаалалтын тухай энэхүү шинэ систем нь усны асуудал улам хүндэрч буй Европ тивийн хувьд цагаа олсон чухал арга хэмжээ болж байгаа юм. Өнөөдөр бидний өмнө нүүрлээд буй усны асуудлыг хойшлуулалгүй шийдвэрлэж усны нөөцөө ирээдүй хойч үедээ хадгалж үлдээх хэрэгтэй байна.

Европ тивийн усны өнөөгийн байдлын тухай зарим баримт

- Европын гадаргын усны 20 % бохирдох аюул тулгараад байна
- Европ тив ундны усныхаа 65 %-ийг гүний усаар хангаж байна
- Европ тивийн хотуудын 60 % нь гүний усны хэт ашиглалттай байна
- Ус намгархаг газруудын 50 % нь гүний ус хэт ашигласны улмаас «устах аюулд өртсөн» гэсэн ангилалд ороод байна
- Өмнөд Европд усалгаатай газар тариалангийн хэмжээ 1985 оноос хойш 20 % нэмэгдсэн байна.

Дэлхийн усны нөөцийн өнөөгийн байдлын талаархи баримтууд

- Дэлхийн усны нөөцийн дөнгөж 1-ээс бага хувийг хүн төрөлхтөн ашиглах боломжтой
- Дэлхийн хэмжээнд 1.2 тэрбум хүн ундны цэвэр усаар гачигдаж байна

Европ тивийн усны байдлыг дэлхийн зарим нутгийнхтай харьцуулбал харьцангуй таатай гэж хэлж болно. Энэ тивд ерөнхийдөө усны гачигдал хараахан байхгүй, мөн ган гачиг, үер зэрэг усны гамшигт үзэгдэл харьцангуй ховор тохиолддог. Гэхдээ Европ тивийн усны чанар төдийлөн хангалттай бус байгаа нь нарийвчилсан судалгаануудаас тодорхой харагдах болжээ.



Бүх нийтийн ашиг сонирхолыг тусгай

Энэхүү хуулийг боловсруулахад олон зуун экспертүүд хамтран ажиллаж санаа бодлоо солилцов. Тухайлбал ХАА, аж үйлдвэрийн салбарынхнаас авахуулаад байгаль орчны чиглэлийн экспертүүд, мөн худалдаа, үйлчилгээний зэрэг хэрэглэгчид болон орон нутгийн, төр засгийн гэх мэт байгууллагын экспертүүд хамрагдсан байна. Ус нь ХАА, загасчлал, усны эрчим хүч, аж үйлдвэр, тээвэр болон аялал жуулчлал гээд маш өргөн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний үндэс суурь болдог тул тэдгээрийн хоорондох хамтын ажиллагаа маш чухал юм. Ер нь, усны асуудал бүх хүмүүст хамаатай болохоор усны бодлого боловсруулахад өөрсдийн нь үйл ажиллагаа, эрх ашиг нь зайлшгүй хөндөгдөж буй талуудын санаа бодлыг тусгах нь чухал байдаг.

Иймэрхүү нилээд цаг хугацаа шаардсан, нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнд Европын Холбооны Усны тухай ерөнхий хуулийн зорилго, хэрэгжүүлэх арга зам, тодорхой хугацааны үе шат, товуудын талаар зөвшилцөлд хүрсэн. Цаашид энэхүү усны хуулийг хэрэгжүүлэхийн тулд улс орнуудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ард иргэд, төрийн бус байгууллагууд болон засгийн газрын бүх түвшний байгууллагуудыг үүнд өргөнөөр татан оролцуулах шаардлагатай гэж үзэж байна.

Усны хуулийг яаж хэрэгжүүлэх вэ ?

Усны тухай энэхүү шинэ хууль нь усны менежментийн талаар зоримог бөгөөд шинэлэг хандлагыг дэвшүүлсэн юм. Энэ хуулийн үндсэн агуулгыг дурьдвал :

- Гол, нуур, гүний ус болон далай тэнгисийн эрэг орчмын бүх усыг хамгаалах
- 2015 он хүртэл Европ тивийн бүх ус "сайн" зэрэглэлийн шаардлага хангасан байх зорилт тавих
- Бүх оролцогч талууд болон улс орнуудын хооронд хил дамжсан хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага тавих
- Усны менежментийн аливаа үйл ажиллагаанд орон нутгийн ард иргэд, төрийн бус байгууллага зэрэг бүх сонирхогч талуудын идэвхтэй оролцоог баталгаажуулах
- Усыг үнэлэх бодлого баримтлахыг шаардах болон ус бохирдуулагчид хохирлыг төлж байх зарчмын хэрэгжилтийг баталгаажуулах
- Байгаль орчныг хамгаалах шаардлага болон түүнээс хамаарагч хүн ардын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэн уялдуулах зэрэг болно.

Тиймээс энэ эмхэтгэлээр Европын Холбооны Усны тухай Ерөнхий Хуулийн зорилт болон зүйл, нөхцөлийн талаархи ерөнхий ойлголтыг илэрхийлэхийг зорьсон болно.



Байгалийн усанд хил хязгаар гэж байхгүй

Гол мөрөн нь улс орны хилээр хязгаарлагдаггүй гэдгийг Европын томоохон голууд болох Дунай, Рейн мөрний сав газарт очиж үзсэн хэн бүхэн мэдэрдэг билээ. Тиймээс эдгээр голуудын усны менежментийг зөв хийх арга зам нь олон улсын хамтын ажиллагаа юм. Олон улсын хамтын ажиллагааны эртний сайхан уламжлалтай Рейн мөрний сав газар зэрэг олон газрын туршлагаас Европын Холбоо байнга суралцаж ирсэн. Энэхүү усны хуульд зааснаар тухайн голын сав газар дахь бүх талууд нягт хамтран ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, улс орнууд тухайн голын сав газрын хэмжээнд менежментийн нэгдсэн төлөвлөгөөтэй байж усны хуульд

заасан тодорхой зорилтуудыг тогтоосон хугацаанд нь ханган биелүүлэх явдал юм.

Ийм төлөвлөгөөнүүдийг гол мөрний сав газрын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд эдгээрт сав газрын геологийн болон ус зүйн байгалийн нөхцөл, урсгалын дээд ба доод хэсэг дэх хэрэглэгчдийн ашиг сонирхол, орон нутгийн, бүсийн болон үндэсний түвшний бүхий л байгууллагууд, мөн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайтар уялдуулан тусгасан байх болно. Ийнхүү усны хууль нь голын сав газрын хэмжээнд усны менежментийг зангидан нэгтгэхийг зорьж байна.

Яргай загас Элба голдоо эргэж ирлээ

Урьд өмнө Элба голыг Европын хамгийн их бохирдсон гол гэж үзэж байлаа. Зүүн болон Төв Европт гарсан улс төрийн өөрчлөлтөөс хойш 1990 онд Рех, Герман болон Европын Холбоо хамтран Элба голыг хамгаалах олон улсын комисс байгуулсан юм. Элбагийн сав газрын улс орнууд судалгааны үндсэн дээр нэгдсэн зарчим, хандлагын талаар зөвшилцөлд хүрч сав газрын усны нөөцийг хамгаалах чиглэлээр нилээд амжилтанд хүрээд байна. Үүний нэг илрэл нь гол мөрний усны цэвэршилтийн байдлыг илтгэгч болдог яргай загас Элба голдоо эргэж ирсэн явдал юм. Голын сав газрын улс



орнуудын олсон амжилтын үр дүнд сав газрын бусад хоёр орон дээрх гэрээ, хамтын төсөлд нэгдэх боллоо. Ийнхүү тус голын сав газрын бүх улсууд Европын Холбооны Усны тухай Ерөнхий хуулийн зорилтуудыг хамтдаа биелүүлэхийн төлөө ажиллаж байна.

Усны асуудал нь бүх нийтийн үйлс мөн

Ус хамгаалах асуудлаар олон улс орон хамтран ажиллахын зэрэгцээ мөн нийгэм-эдийн засгийн янз бүрийн салбаруудын төлөөлөгчид үүнд нэгдэх шаардлагатай. Бид гэр орондоо ч, үйлдвэр, ХАА-д усыг өдөр тутмынхаа амьдрал ахуйд тасралтгүй хэрэглэдгийн хувьд хууль эрхийн актыг хэрэгжүүлэх үйлсэд хүн бүр гар бие оролцох ёстой. Тиймээс Усны хууль нь усны менежментийн үйл ажиллагаанд бүх нийтийн идэвхитэй оролцоог хөхүүлэн дэмжиж байна. Бид усны тоо хэмжээ болон чанарт өөрсдийнхөө нөлөөллийг ойлгохын хэрээр түүнийг хамгаалах үйлсэд идэвхитэй оролцож өөрсдийн тус дэмээ нэмэрлэх хэрэгтэй. Үүний тулд Усны хууль нь тухайн орны усны нөөцийг хамгаалах болон түүний менежментийн үйлст иргэн бүрийн оролцоог дэмжиж байна.

Энэхүү хууль нь иргэдийн төлөөлөгчид болон шийдвэр гаргагчдын хамтын ажиллагааны үр дүн юм. Дараагийн шатны арга хэмжээ нь "Голын сав газрын

Менежментийн Төлөвлөгөө" боловсруулах явдал юм. Энэхүү төлөвлөгөөнд голын сав газрын тодорхойлолт, шинж чанаруудын талаарх судалгааны дүн, гол мөрний усанд үзүүлж буй хүний үйл ажиллагааны нөлөөллийн тухай мэдээ, баримт, түүнчлэн ус ашиглалт, хэрэглээний эдийн засгийн талын дүн шинжилгээг тусгас байна. Үүний дараа сонирхогч талууд болон бүх хэрэглэгчид усны талаар авах арга хэмжээ, үйл ажиллагааныхаа зарчим, арга замаа хамтдаа тохирч улмаар хэрэгжүүлж эхлэх болно.

Төрийн бус байгууллагууд, орон нутгийн төлөөлөгчид, бүх шатны олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааны хуулийн хэрэгжүүлэлтийн бүх үе шатанд аливаа үйл ажиллагааны үр дүн, ил байдлыг хангахад шийдвэрлэх хүчин зүйлийн нэг байдаг. Ийм оролцоо нь байгаль орчин ба түүнээс хамаарал бүхий хэрэглэгчдийн ашиг сонирхол, тэдгээрийн хоорондын тэнцвэрт байдлыг хадгалах замаар үргэлжлэх ёстой.



Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF) усны асуудлаар олон нийтийн ухамсар, ойлголтыг Дээшлүүлэхэд хамтран ажиллаж байна.

2000-2001 онд Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Европын цэнгэг усны Хөтөлбөр нь Европын Комиссийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Усны Ерөнхий хуулийн зарим заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой 3 цуврал семинарыг зохион байгуулсан юм. Үүнд: (1) Ус ба Хөдөө аж ахуй, (2) Гол мөрний сав газрын нэгдсэн Менежментыг хэрэгжүүлэхэд Ус намгархаг газрын Гүйцэтгэх үүрэг, (3) Гол мөрний сав газрын төлөвлөлтийг сайжруулах чиглэлийн туршлагаууд гэсэн сэдвээр явагдав.

Дээрх семинаруудын гол зорилго нь Усны хуулийн талаар хэлэлцүүлэг, мэтгэлцээг өрнүүлэх бололцоо бүрдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах, ил тод байдлыг хангах, харилцан туршлага солилцоход дэмжлэг үзүүлэх, хуулийн чухал заалтуудыг хэрэгжүүлэх талаар "сайн туршлагаууд"-ыг илрүүлэх зэрэгт оршиж байв. Семинаруудын үр дүн, материалыг дараах веб сайтаас үзэж болно.

www.panda.org/europe/freshwater/seminars/seminar.html

Усны тогтвортой хэрэглээ

Маш олон төрлийн үйл ажиллагаа усны нөөц, чанарт нөлөөлж байгааг мэдрэхийн хэрээр усны нөөцийг хомсдохоос болон бохирдохоос хамгаалахын ач холбогдлыг хүн төрөлхтөн сайтар ойлгож эхэллээ. Мөн усны хэрэглээ үргэлжлэн өсөж байгаа болохоор энэ нь улам ч чухал асуудал болж байна. Иймд Усны хуулийн заалтуудыг үр ашигтайгаар хэрэгжүүлэн хойч үедээ чанарын өндөр шаардлага хангасан хангалттай усны нөөцийг үлдээх нь өнөөгийн биднээс хамаарч байна.

Усны хомсдол нүүрлэх боллоо

Дэлхий даяар усны хомсдол өсөн нэмэгдэхийн хэрээр хүмүүс усыг дахин давтан ашиглах арга замыг эрэлхийлэх болов. Ашигласан усыг цэвэрлэн давтан ашигласнаар түүнийг гүнээс татаж авах зардал хэмнэгдэх үр ашигтай. Түүнчлэн байгалиас авах усны хэмжээ багасах тул усны нөөцийг хэмнэх, цаашид хадгалан үлдээх боломж дээшлэнэ. Усыг давтан ашиглахын ганц сөрөг тал нь гэвэл байгалийн усны системд эргүүлэн нийлүүлж буй усны хэмжээ багасах явдал юм.

Усыг давтан ашиглах нь бохир усны менежментийн чухал аргуудын нэг байдаг. Тухайн усан хангамжийн боломжийг дээд зэргээр үр ашигтай ашиглахын тулд усыг давтан ашиглах зарчмыг баримтлах болсон билээ. Үүнд богино ба урт хугацааны хэрэгцээ болон байршилтай холбоотой асуудлыг харгалзан үзсэн байх шаардлагатай. Тухайлбал, хуурай гандуу нутагт газар тариаланд шаардлагатай ус хязгаарлагдмал байх тул бохир усыг тодорхой цэвэршүүлэлт хийсний дараа нэмэлт хэлбэрээр усалгаанд ашиглаж болох юм. Гэхдээ тухайн усны чанараас хамааран ямар ургамлын усалгаанд ашиглах вэ гэдгээ тооцох хэрэгтэй. Тухайлбал, эрдэсжилт ихтэй усыг давсанд тэсвэргүй ургамалд хэрэглэх нь зохимжгүй бөгөөд харин давсанд тэсвэртэй тэжээлийн ургамал болон ойжуулалтын нөхцөлд дахин давтан хэрэглэж болох талтай.

Үнэн хэрэгтээ өнөөдрийн байдлаар эрдэсжилттэй усыг давсанд тэсвэртэй зарим ХАА-н таримал болон мод бутны усалгаанд нилээд хэмжээгээр хэрэглэж байна. Усалгаатай тариалан нь ус намгархаг газрын ойролцоо байгаа бол ашиглагдсан усыг дахин ус намгархаг газарт оруулж болдог. Гэхдээ дахин хэрэглэж буй усны чанар нь загас, усны шувуу зэрэг ус намгархаг нутгийн амьд байгальд хор нөлөөгүй байх талаас нь болгоомжлох хэрэгтэй. Мөн ус намгархаг газраар дамжин өнгөрч буй ус нь бохирдуулагч бодис хуримтлуулахгүйн тулд хангалттай хэмжээтэй байх шаардлагатай.

Усны бодит үнийн тухайд

Усыг аливаа худалдааны эд зүйлс бус харин байгалийн өв, баялаг гэдэг утгаар нь ойлгох ёстой. Тиймээс усыг үнэлгээтэй болгох нь түүний ашиглалтыг үр өгөөжтэй, тогтвортой болгоход чухал ач холбогдолтой. Ийм шалтгаанаар Европын олон улс усаа үнэтэй болгоод удаж байна. Олон судалгаанаас үзэхэд усыг үнэтэй болгосноор усны нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглахад түлхэц болдог байна. Тухайлбал, Европын Байгаль орчны агентлагийн судалгаагаар усыг үнэтэй болгож тоолуурын систем нэвтрүүлснээр усны хэрэглээг 10-25 хүртэл хувиар хэмнэсэн тооцоо гарчээ.

Европын Холбооны Усны тухай Ерөнхий хуульд оорин гишүүн орнуудад бүх ус хэрэглэгчдийн оролцоотой усыг үнэлэх бодлого боловсруулахыг заасан байна. Усны хуулийн зарчмаар бол ус бохирдуулагч нь хохирол учруулсныхаа төлөө заавал төлбөр төлөх хариуцлага хүлээх ёстой.

Энэхүү усны хуулиар гол мөрний Сав Газрын Албадууд нь тухайн нутгийн газарзүйн байрлал, нийгэм эдийн засгийн болон улс төрийн онцлогийг харгалзан усны үнэ, төлбөрийн уян хатан системийг боловсруулах үүрэг хүлээхээр заасан байна. Өөрөөр хэлбэл, айл өрхийн унд ахуйн хэрэглээ, үйлдвэр, ХАА зэрэг олон янзын салбарын ус хэрэглээний үнийг ангилан тогтоох талаар судалгаа хийж, улмаар усны дэд бүтцийг сайжруулахад улсын болон хувийн салбараас хийх хөрөнгө оруулалтын урт хугацааны тооцоог эдгээр үнэд харгалзах явдал юм. Мөн өнөөгийн болон ирээдүйн олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн усны хэрэгцээ ба хангалтыг тэнцвэржүүлсэн системийг сонгон авахын тулд зөвлөлгөөний чанартай арга хэмжээнүүдийг зохион байгуулах болно. Үүний зэрэгцээ ус нь нийгмийн эрүүл мэндийн хувьд амин чухал зүйл болдог тул зарим газар, нутагт наад захын хэрэгцээний усны үнийг хэрэглэгчдийн төлбөрийн чадварт тааруулан тогтоох талаар энэхүү Усны хуульд заасан байна.

Франц улсын усны үнэлгээний тухайд

Франц улс нь усаа үнэ, төлбөртэй болгоод удаж байгаа билээ. Саяхан тус улсын усны үнэлгээний талаар хийсэн судалгааны дүнгээс үзвэл цэвэр усны хангамж болон бохир ус цэвэрлэх үйлчилгээнд 1 шоо метр ус 0.8 - 3.15 Евро-гийн үнэтэй байжээ. Яагаад ийм хэлбэлзэлтэй байгааг дараах хэдэн хүчин зүйлтэй холбоотой гэж үзсэн байна. Үүнд :

- Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн төрөл, зүйл,
- Ундны ус хуваарилалт ба олборлох арга зам,
- Хэрэглэсэн буюу бохир усыг цуглуулах систем ба цэвэрлэгээний төрөл,
- Байгалийн нөхцөл,
- Хүн амын суурьшилын нягтрал зэрэг болно.

Европын Холбооны Усны тухай Ерөнхий хуулийг хэрэгжүүлснээр тус тивийн хэмжээнд усны үнэ харилцан адилгүй болох уу?

Энэхүү усны хууль нь усны үнийг үр ашигтай байхаар тогтоохыг зорьж байгаа хэдий ч Европ даяар нэгдсэн нэг үнэтэй байх шаардлага тавиагүй юм. Усны үнэ нь дээр дурьдсан хүчин зүйлүүд болон байгаль орчны шаардлага хангах зардлыг шингээх зэрэг бусад хүчин зүйлээс хамаарч улс орон, бүс нутаг бүрт харилцан адилгүй байна. Харин Европ даяар усны үнэ төлбөртэй холбоотой асуудлыг ил тод байдлаар гаргах нь хуулийн нийтлэг зүйл юм. Тухайлбал, хэн ус хэрэглэж байна, хэн бохирдуулж байна, энэ нь ямар үнэтэй болов, түүний үнийг хэн төлж байна гэх зэрэг мэдээллийг олон нийт ил тодоор мэдэх бололцоотой болно. Ингэснээр, нийгэм-эдийн засаг ба байгаль орчны ашиг сонирхлыг уялдуулсан усны төлбөрийн механизмыг хэрэгжүүлэхийн төлөө хүн бүрийн оролцоог хөхүүлэн дэмжих болно.

Хамтдаа хэрэгжүүлье

Европын Холбооны Усны тухай Ерөнхий хуулийг хэрэгжүүлэх арга зам нь ус хэрэглэгч бүх талуудын хамтын оролцоон дээр үндэслэсэн онцгой өвөрмөц хэлбэр юм. Мөн түүнчлэн энэ хууль нь Европын Комисс, Европын Холбооны гишүүн орнууд болон Европын холбоонд нэгдэхээр нэр дэвшээд буй орнууд, мөн бүх сонирхогч талуудад усны хуулийн заалт, зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллах шинэ боломжийг бүрдүүлж байна.

Энэхүү Усны тухай Ерөнхий Хуулийн заалт, зорилтууд нь иж бүрэн, хэтийн чиглэлтэй, өргөн цар хүрээтэй учир түүний хэрэгжилтийг хангахын тулд үйл ажиллагааны олон чиглэлээр удирдамж заавар боловсруулах шаардлагатай болохыг бүх талууд хүлээн зөвшөөрсөн байна. Тиймээс, Европын Холбооны гишүүн орнууд болон Европын Комисс хамтран Усны хуулийг хэрэгжүүлэх Ерөнхий Стратегийг боловсруулж 2001 оны 5-р дугаар сард зөвшилцөлд хүрчээ.

Хуулийн чухал товууд:

■ 2003 оны 12 дугаар сар

Үндэсний болон бүсийн чанартай усны хуулиудыг Европын Холбооны Усны тухай Ерөнхий хуультай уялдуулан шинэчлэх. Сав газрын хамтын ажиллагааг хэрэгжүүлж эхлэх.

■ 2004 оны 12 дугаар сар

Усны нөөцөд үзүүлж буй ачаалал, нөлөөллийн талаар эдийн засгийн болон бусад дүн шинжилгээ хийж дуусгах

■ 2006 оны 12 дугаар сар

Усны менежментийн үндэс болох мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх

■ 2008 оны 12 дугаар сар

Гол мөрний сав газрын менежментийн төлөвлөгөөг олон нийтэд танилцуулах

■ 2009 оны 12 дугаар сар

Гол морний сав газрын нэгдсэн менежментийн анхны төлөвлөгөөг хэвлэх

■ 2015 оны 12 дугаар сард

Европын бүх ус "сайн" зэрэглэлд хүрсэн байна.

Европын Комисс

Европын Холбооны Усны тухай Ерөнхий Хууль: Харилцан суралцъя!
Люксембург: Европын Холбооны Албан ёсны Хэвлэлийн Газар (Luxembourg: Office for Official Publications of the European Communities)

2005 - 12 pp. - 14.85 x 21 cm

ISBN 92-894-8307-5

